

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН  
Я.ШАРАВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар Б-16

Мөрөн

ЦАЗН экспедиц ажиллуулах,  
нэмэгдэл хөлс олгох тухай

Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 50 дугаар зүйлийн 50.2, 52 дугаар зүйлийн 52.1, 53 дугаар зүйлийн 53.1, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1, “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5, “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтууд, ЦУОШГ-ын даргын 2017 оны А/56 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны зөвшөөрөгдсөн хугацаанд /2017 оны 5 дугаар сарын 01-нээс 9 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал/ үүл үзэгдлийн нэмэлт судалгаа-дүгнэлтийг өдөр тутам хийж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах цаг агаарын тодорхой нөхцөл бүрдэх үеийг оновчтой зөв тогтоож ажиллахыг синоптик инженерүүд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, экспедицийн асуудал хариуцсан технологич инженер Г.Адъяасүрэн нарт үүрэг болгосугай.
2. Хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны үед цаг агаарын тодорхой нөхцөл бүрдэхээс дуустал хугацаанд нэмэлт судалгаа-дүгнэлт хийж ажилласан синоптик инженерт цагийн бүртгэлээр тооцож нэмэгдэл хөлс олгохыг ня-бо Н.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
3. Цаг агаарын тодорхой нөхцөлд нэмэлт судалгаа-дүгнэлт хийж ажилласан синоптик инженерийн цагийн бүртгэлийг тушаалын 1 дүгээр, ноцоох зуухыг хариуцаж хөдөлмөрийн хугацаатай гэрээгээр ажиллах ажилтаны нэрсийн жагсаалт, цалин хөлсний хэмжээг тушаалын 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Хөдөлмөрийн хугацаатай гэрээгээр ноцоох зуухыг хариуцан ажиллах ажилтаныг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, нэмэлт судалгаа-дүгнэлтийг хийж ажилласан синоптик инженерүүдийн цагийн бүртгэл хөтлөлтийг хариуцан, экспедицийн болон ноцоох зуухны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж, заавар зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллахыг инженер Г.Адъяасүрэнд үүрэг болгосугай.

ДАРГА



А.ҮНЭНБАЯР